



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

“Жанжин мөнгөн шат” ХЗХ-ны хадгаламж, зээлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн
хугацааг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 7.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жанжин мөнгөн шат” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2025 оны 3 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтад холбогдох тэмдэглэгээг 21 хоногийн дотор хийлгэхийг “Жанжин мөнгөн шат” ХЗХ /О.Тамир/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН